



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/142 /СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв
ТБОНӨБҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуувь



Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Ауд. 02.29 № 256

танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА.
Х.ЦЭРЭНХОРЛОО ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520286



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Х.Цэрэнхорлоо Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн “Булган сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймгийн Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн салбар дундын хамтын ажиллагаа олон нийтийн оролцоог сайжруулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлоход оршино.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахрloger программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 301,806.0 мянган төгрөгөөс тооцон 6,036.12 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,036.1 мянган төгрөгөөр тооцсон нь төсвийн байгууллагын хувьд зардал гол үзүүлэлт байдагтай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймгийн Булган сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,246.8 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	20,890.41	23,460.62	2,570.21
Үндсэн хөрөнгө	516,555.89	541,415.89	24,860.0
Хуримтлагдсан элэгдэл	(52,985.49)	(63,168.82)	(10,183.33)
Нийт хөрөнгө	484,460.81	501,707.69	17,246.88
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	484,460.81	501,707.69	17,246.88
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	484,460.81	501,707.69	17,246.88

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 2,570.21 мянган төгрөгөөр өссөн нь нормын хувцас худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 13,250.0 мянга төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, ажилчдын хандиваар 1,145.0 мянган төгрөгийн тавилга, хэрэгсэл, Сумын хөрөнгө оруулалтаар 5000,0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, 3000,0 мянган төгрөгөөр сувилалын зориулалтаар 5 ханатай гэр хүлээн авсан, батлагдсан төсвөөс 2465,0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж тавилга, эд хогшил худалдан авснаар үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 501,707.69 мянган төгрөг болж 17,246.88 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 290,212.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шинжүүлгээр 274,673.3 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 5,016.20 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжихээр 10,523.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 290,211.5 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь түлш халаалт, цахилгаан эрчим хүчний зардал хэмнэсэнтэй холбоотой байна.

Нэмэлт төсөв: Аймгийн төсвөөс ахмад настны болон хүүхдийн сувилалын зардалд 1,204.5 мянган төгрөг, Монголын сумын эмч сувилагчдын нийгэмлэгээс 25.4 мянган төгрөгийн санхүүжилтээр нэмэлт дансны орлогыг бүрдүүлжээ.

Тус орлогыг зориулалтын дагуу эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 304.5 мянган төгрөг, хоол хүнсэнд 900.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд 25.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31 эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 51,360.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,215.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,252.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 30,993.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 13,899.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тайлант хугацааны эцэст 1,252.10 мянган төгрөгийн шатахуун /талон / нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.5.Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов

2. Эмийн худалдан авалтыг тендер зарлаагүй шууд хийсэн бөгөөд Эмийн эргэлтийн сангаас 3,046.7 мянган төгрөгийн нэмэгдэлтэй үнээр эм нийлүүлсэн нь ТБОНӨХБҮХАТ хуульд нийцэхгүй бөгөөд үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Тайлант хугацаанд нийт 75,893.7 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаас 27,946.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ е-баримтгүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитаар дараах 14,113.70 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймгийн “Булган сумын Эрүүл мэндийн төвийн” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчилд 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймгийн “Булган сумын Эрүүл мэндийн төвийн”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн “Булган сумын Эрүүл мэндийн төв”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл
 - 1.1. Илрүүлэлт: Ерөнхий журналаас шатахууны зардлын түүвэрлэлт хийхэд шатахууныг бөөн дүнгээр орлого авч бөөн дүнгээр зарлага хийсэн байна.
 - 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгө шамшигдах, дотоод хяналт алдагдах.
 - 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" дагаж мөрдөх.
 - 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.
2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа
 - 2.1. Илрүүлэлт: Тавилга эд хогшилын дансанд 14 нэр төрлийн 3,204.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмийг бүртгэсэн байна.
 - 2.2. Эрсдэл: Санхүүгийн байдлын тайлан тооцооллын хувьд алдаатай байх
 - 2.3. Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг зөв ангилах, залруулан бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС 17, бусад холбогдох заавар, журмыг мөрдөж ажиллах
 - 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана
3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

- 3.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээ нөхсөн, ашиглагдахгүй байгаа 124,6 мянган төгрөгийн хэрэглээний программ хангамжийг данс бүртгэлээс хасаагүй ба одоо ашиглагдаж байгаа 770.0 мянган төгрөгийн өртөг бүхий санхүүгийн программ хангамжыг бүртгэлд аваагүй байна.
- 3.2 Эрсдэл: Хөрөнгийн ашиглалтын үр өгөөж буурах, хөрөнгө шамшигдах.
- 3.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС 17-ын дагуу ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах, хөрөнгийг бүртгэлд тусгах.
- 3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Санхүүгийн тайлан

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			СТ-1А
			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,890,411.30	23,460,617.80
35	БАРАА МАТЕРИАЛ	20,890,411.30	23,460,617.80
351	Түүхий эд материал	2,340,514.82	2,030,624.82
35110	Тусгай зориулалттай материал	2,340,514.82	1,805,514.82
35130	Эм боох материал	-	225,110.00
354	Хангамжийн материал	18,549,896.48	21,429,992.98
35420	Аж ахуйн материал	7,751,887.98	10,814,827.98
35430	Сэлбэг хэрэгсэл	7,205,000.00	7,205,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,252,165.00	1,252,165.00
35470	Бусад хангамжийн материал	2,158,000.00	2,158,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	463,570,399.01	478,247,071.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	463,570,399.01	478,247,071.20
392	Биет хөрөнгө	456,170,399.01	470,847,071.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	407,625,610.49	407,625,610.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,574,606.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,860,400.00	26,860,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,420,399.94)	(25,780,399.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,364,389.22	51,549,389.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,358,382.42)	(15,335,525.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,863,798.00	14,538,798.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,321,564.62)	(9,720,661.37)
39214	Бусад үндсэн хөрөнгө	29,959,698.00	32,959,698.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,403,149.72)	(5,275,630.86)
393	Биет бус хөрөнгө	7,400,000.00	7,400,000.00
39301	Програм хангамж	482,000.00	482,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(482,000.00)	(482,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,400,000.00	7,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	484,460,810.31	501,707,689.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	484,460,810.31	501,707,689.00
51	Засгийн газрын хувь оролцоо	484,460,810.31	501,707,689.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,643,326.56	181,643,326.56
51101	Өмч: - төрийн	181,643,326.56	181,643,326.56
512	Хуримтлагдсан үр дүн	62,384,568.50	79,631,447.19
51210	Өмнөх үеийн үр дүн	62,384,568.50	62,384,568.50
51220	Тайланг үеийн үр дүн	-	17,246,878.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	240,432,915.25	240,432,915.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	484,460,810.31	501,707,689.00

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН			СТ-2А
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	237330100.00	319052899.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2734500.00	27610395.50
120	Нийтлэг татварын бус орлого	2734500.00	27610395.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2734500.00	27610395.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2734500.00	27610395.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	234595600.00	291442504.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	234106600.00	274673300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	234106600.00	274673300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	489000.00	1229900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489000.00	1229900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	10523100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	0.00	10523100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	5016204.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	5016204.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	246673681.49	301806020.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	246673681.49	301806020.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239619496.96	301804959.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146629012.52	189283448.37
210101	Үндсэн цалин	142060894.52	182903063.37
210104	Урамшуулал	4568118.00	6380385.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16886799.95	24561200.00
210201	Тэтгэврийн даатгал	9603100.00	16682900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1165400.00	1926400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2913399.95	1568200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	291500.00	398500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2913400.00	3985200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8909183.00	9350857.00
210301	Гэрэл, цахилгаан	2676568.00	3087575.00
210302	Түлш, халаалт	6052615.00	5917782.00
210303	Цэвэр, бохир ус	180000.00	345500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13224480.00	13903009.00
210401	Бичиг хэрэг	990270.00	1318743.00
210402	Тээвэр, шатахуун	9774480.00	9825400.00
210404	Ном, хэвлэл	0.00	200000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1199830.00	1150170.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	959900.00	1408696.00
2105	Нормативт зардал	19461118.00	25798269.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12000000.00	18898385.50
210502	Хоол, хүнс	5743118.00	6899883.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1803600.00	6535000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	913600.00	535000.00
210604	Урсгал засвар	890000.00	600000.00
2107	Томилолт, зочны зардал	590000.00	864000.00
210702	Дотоод албан томилолт	590000.00	864000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15501770.00	19316738.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14980920.00	18208738.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	838000.00
210803	Даатгалын үйлчилгээ	197950.00	200000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	53000.00	70000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16613533.49	12192437.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1727841.00	2009110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	14885692.49	10,183,327.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7054184.53	1061.59
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1660184.53	1061.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1660184.53	1061.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-9343581.49	17246878.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-9343581.49	17246878.69

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			СТ-2А
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	234,595,600.0	291,442,504.0
13.0	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	234,595,600.0	291,442,504.0
1,310.0	Улсын төвлөрсөн төсвөөс	234,106,600.0	274,673,300.0
131,007.0	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	234,106,600.0	274,673,300.0
1,311.0	Нэмэлт санхүүжилтийн орлого	489,000.0	1,229,900.0
131,104.0	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	489,000.0	1,229,900.0
1,320.0	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	10,523,100.0
132,001.0	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	10,523,100.0
1,340.0	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	5,016,204.0
134,002.0	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	5,016,204.0
2.0	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	231,962,699.5	291,442,504.0
21.0	УРСГАЛ ЗАРДАЛ	231,962,699.5	291,442,504.0
210.0	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	224,908,515.0	291,441,442.4
2,101.0	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146,629,012.0	189,283,448.4
210,101.0	Үндсэн цалин	142,060,894.0	182,903,063.4
210,104.0	Урамшуулал	4,568,118.0	6,380,385.0
2,102.0	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,480,800.0	24,561,200.0
210,201.0	Тэтгэврийн даатгал	10,197,100.0	16,682,900.0
210,202.0	Тэтгэмжийн даатгал	1,165,400.0	1,926,400.0
210,203.0	ҮОМШӨ-ний даатгал	2,913,400.0	1,568,200.0
210,204.0	Ажилгүйдлийн даатгал	291,500.0	398,500.0
210,205.0	Эрүүл мэндийн даатгал	2,913,400.0	3,985,200.0
2,103.0	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,909,183.0	9,350,857.0
210,301.0	Гэрэл, цахилгаан	2,676,568.0	3,087,575.0
210,302.0	Түлш, халаалт	6,052,615.0	5,917,782.0
210,303.0	Цэвэр, бохир ус	180,000.0	345,500.0
2,104.0	Хангамж, бараа материалын зардал	12,839,000.0	13,903,009.0
210,401.0	Бичиг хэрэг	990,270.0	1,318,743.0
210,402.0	Тээвэр, шатахуун	9,689,000.0	9,825,400.0
210,404.0	Ном, хэвлэл	-	200,000.0
210,405.0	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,199,830.0	1,150,170.0
210,406.0	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	959,900.0	1,408,696.0
2,105.0	Нормативт зардал	19,517,209.0	23,153,080.0
210,501.0	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,000,000.0	13,908,100.0
210,502.0	Хоол, хүнс	5,799,209.0	6,717,040.0
210,503.0	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,718,000.0	2,527,940.0
2,106.0	Эд хогшил, урсгал засварын зардал	1,803,600.0	9,000,000.0
210,601.0	Багаж, техник, хэрэгсэл	913,600.0	3,000,000.0
210,604.0	Урсгал засвар	890,000.0	6,000,000.0
2,107.0	Томилолт, зочны зардал	590,000.0	864,000.0
210,702.0	Дотоод албан томилолт	590,000.0	864,000.0
2,108.0	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,411,870.0	19,316,738.0
210,801.0	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,980,920.0	18,208,738.0
210,802.0	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.0	838,000.0
210,803.0	Даатгалын үйлчилгээ	197,950.0	200,000.0
210,805.0	Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,000.0	70,000.0
2,109.0	Бараа үйлчилгээний бусад зардал	1,727,841.0	2,009,110.0
210,901.0	Бараа үйлчилгээний бусад зардал	1,727,841.0	2,009,110.0
213.0	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,054,184.5	1,061.6
2,133.0	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,660,184.5	1,061.6
213,303.0	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,660,184.5	1,061.6



СТ-4А

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	62,384,568.50	0.00	484,460,810.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	62,384,568.50	0.00	484,460,810.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайланг үеийн үр дүн					0.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	62,384,568.50	0.00	484,460,810.31
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	62,384,568.50	0.00	484,460,810.31
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	62,384,568.50	0.00	484,460,810.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	17,246,878.69	0.00	17,246,878.69
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,643,326.56	240,432,915.25	79,631,447.19	0.00	501,707,689.00



4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304,044,700.0	290,211,542.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,044,700.0	290,211,542.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,044,700.0	290,211,542.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,489,200.0	189,283,448.4
210101	Үндсэн цалин	185,162,200.0	182,903,063.4
210104	Урамшуулал	11,327,000.0	6,380,385.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,561,200.0	24,561,200.0
210201	Тэтгэврийн даатгал	16,682,900.0	16,682,900.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,926,400.0	1,926,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,568,200.0	1,568,200.0
210204	Ажилгүйдлийн даатгал	398,500.0	398,500.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,985,200.0	3,985,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,523,100.0	9,350,857.0
210301	Гэрэл, цахилгаан	3,220,000.0	3,087,575.0
210302	Түлш, халаалт	6,923,100.0	5,917,782.0
210303	Цэвэр, бохир ус	380,000.0	345,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,896,100.0	13,877,609.0
210401	Бичиг хэрэг	1,633,000.0	1,318,743.0
210402	Тээвэр, шатахуун	9,800,000.0	9,800,000.0
210404	Ном, хэвлэл	200,000.0	200,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,180,000.0	1,150,170.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,460,300.0	1,408,696.0
2105	Нормативт зардал	25,924,900.0	21,948,580.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,924,900.0	13,603,600.0
210502	Хоол, хүнс	6,000,000.0	5,817,040.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.0	2,527,940.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.0	9,000,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.0	3,000,000.0
210604	Урсгал засвар	6,000,000.0	6,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	1,133,400.0	864,000.0
210702	Дотоод албан томилолт	1,133,400.0	864,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй зардал	19,506,800.0	19,316,738.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	18,226,800.0	18,208,738.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	880,000.0	838,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.0	200,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.0	70,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,010,000.0	2,009,110.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,010,000.0	2,009,110.0